ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

2019

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГАРЧИГ

БИД ХЭН БЭ
хуудас 4

ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ
хуудас 4

ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ
хуудас 5

ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ
хуудас 13

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ
хуудас 5

«ЗОРИГТОН» ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ
хуудас 21

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ
хуудас 21



ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ
хуудас 25

ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД
хуудас 31

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ, ХӨГЖИЛ
хуудас 25

САНХҮҮГИЙН ТАЙЛАН
хуудас 25

2019 ОНД ХЭВЛЭСЭН НОМ, ТОВХИМОЛ

Бидний үйл ажиллагаа хүрсэн газрууд



МЭИ-ийн НИЙТ ГИШҮҮД, ДЭМЖИГЧИД



18-аас доош 18-24 25-35 36-44 45-64 65-аас дээш

73% эмэгтэй 27% эрэгтэй

2019 ОНД ЭЛССЭН ГИШҮҮД, ДЭМЖИГЧИД



18-аас доош 18-24 25-35 36-44 45-64 65-аас дээш

63% эмэгтэй 37% эрэгтэй

БИД ХЭН БЭ

Нобелийн шагналт олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад баримт бичгүүдэд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхийн төлөө үйл ажиллагаа өрнүүлдэг дэлхий нийтийн хөдөлгөөн бөгөөд Монгол Улсад 1994 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид Монгол улсын хэмжээнд 6000 гаруй гишүүн дэмжигчидтэй, нийслэл болон орон нутгийн, мэргэжил, сонирхлын зэрэг 25 бүлэгтэйгээр ажиллаж байна.

БИД ЮУ БОЛСНЫГ БАРИМТЖУУЛАН, ЗАСГИЙН ГАЗАРТ ШАХАЛТ ҮЗҮҮЛЭН, ХҮН БҮРИЙН ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХИЙГ ШААРДДАГ

2019 он дэлхий дахинд ч, Монгол улсад ч иргэдийн эсэргүүцэл нэмэгдэж, хариуцлага тооцох, хуулийн хэрэгжилтийг шаардах асуудлаар өөрчлөлт гарсан жил байлаа. Айдас, ялгаварлал, нөөцийн тэгш биш хуваарилалтаас ангид амьдарч, шударга бус тогтолцооны эсрэг зогсох зоригтнуудын дуу хоолой нэмэгдэхийн хэрээр эрх баригчид шүүхийн хяналтаас мултрах, шүүх тогтолцоог хараат болгох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэд халдах, идэвхитэй иргэн, иргэний нийгмийн орон зайг хумихаар улиаран санаархав.

Эрх баригчид хоосон, худал амлалт, өөрсдийн бодлогын алдаандаа хэн нэгэн хүн болоод хэсэг бүлэг хүмүүсийг буруутгаж үзэн ядуулж талцуулсан нөгөө л хандлагаараа асуудалд хандсаар.

Элдвээр цоллуулж, хараалгаж зүхүүлж, заналхийлэл, айлган сүрдүүлэлтэнд өртөж, цагдаа шүүхэд дуудагдаж, тайван жагсаалаа тараалгасан, ч цахим орчинд шударга үнэний дуу хоолой болон өөрчлөлтийг шаардсан тэдгээр зоригтнууд болоод иргэний нийгмийнхний эв нэгдэл дуу хоолойны ачаар залуус улам бүр хүний эрхийн мөн чанар, үнэ цэнийг мэдэрч, хүний эрхийн хмагаалалгчид, иргэний нийгмийн хүрээг тэлж байна. 2019 он хүний эрхийн салбарт ухралтыг ч, бас амжилтыг ч авчирсан жил байлаа.

Цаазын ялгүй, хүн бүр эрх чөлөөтэй, адил тэгш эрхтэй Монгол улс, дэлхий ертөнцийг цогцлооход бидэнд хийх зүйл багагүй байна. 25 жилийн турш болоод 2019 онд бидэнтэй хамт байж, хэцүү цаг үед бидэнд эр зориг, урам өгч, хүний эрхийн төлөө тэмцэх хүч өгдөг гишүүд, дэмжигч, хамтран ажиллагч түншүүддээ хүндэтгэл, талархлаа илэрхийлье.

УДИРДАХ ЗӨВЛӨЛ

С.Ганчимэг
Удирдах зөвлөлийн дарга

С.Очирбал
Удирдах зөвлөлийн дэд дарга

А.Отгончимэг
Санхүү хариуцсан гишүүн

Б.Энхтуяа
Кампанит ажил хариуцсан гишүүн

М.Батбаатар
Судалгаа хариуцсан гишүүн

Я.Мөнхчимэг
Кампанит ажил хариуцсан гишүүн

З.Балдорж
Залуучууд хариуцсан гишүүн

Т.Жанерке
Хэвлэл мэдээлэл хариуцсан гишүүн

Б.Болдсүрэн
Хүний эрхийн боловсрол хариуцсан гишүүн

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

С.Очирбат
Хяналтын зөвлөлийн дарга

Б.Наранбаатар
Хяналтын зөвлөлийн гишүүн

Г.Сүхбат
Хяналтын зөвлөлийн гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ТОВЧОО

Б.Алтантуяа
Гүйцэтгэх захирал

Г.Амарзаяа
Кампанит ажил хариуцсан зохицуулагч

П.Мөнхжаргал
Кампанит ажил хариуцсан зохицуулагч

Т.Ариунаа
Санхүүгийн ажилтан

Я.Цэцэнзаяа
Залуучууд, цахим хэвлэл мэдээлэл хариуцсан зохицуулагч
2018 оны 09 сараас

Т.Болорсувд
Өсөлт, хөгжил хариуцсан зохицуулагч

Н.Золзаяа
Гишүүнчлэл, харилцаа хариуцсан зохицуулагч
2018 оны 10 сараас

Хүний эрхийн төлөө хамтран зүтгэгч анд нөхөд, уран бүтээлчид ээ, Эмнести Интернэшнлийн гишүүд дэмжигчид ээ

Тэртээ 1961 онд Эрх чөлөөний төлөө хундага өргөсөн Португалын хоёр оюутныг суллуулах уриалга гаргаснаар Эмнести Интернэшнл үүсч байсан бол Монгол улсад 90-ээд оны эхээр ардчилал эрх чөлөөний төлөөх оюутан залуусын, үзэл бодлоо илэрхийлэх, хуран чуулах эрхийнхээ төлөө тэмцэж байсан багш нарын ажил хаялтыг тэргүүлэгчид, шударга ёсны төлөөх Хуульчдын, Эмч нарын, Эмэгтэйчүүдийн зэрэг нийгмийн идэвхитэй бүлгүүд нэгдэж 1994 онд Монголын Эмнести Интернэшнлийг байгуулж байсныг дурсан санахад таатай байна.

Монголын Эмнести Интернэшнлийн өнгөрсөн 25 жилийн ололт амжилт, алдаа оноо, түүхэн дурсамжаа хуваалцахаар өнөөдөр бид та бүхнийг урьсандаа таатай байна. Энэ хугацаанд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа, хүний эрхийн кампанит ажлаараа бид 300 гаруй байгууллагатай хамтарч, түншилж ямар нэг хэмжээгээр бүх аймагт хүрч ажиллажээ. Гишүүд, дэмжигчдийн маань хүрээ ч өргөжиж, 7000 орчим болсон байх бөгөөд тэдний 70 гаруй хувь нь залуучууд байна.

Хүний насаар 25 жил гэдэг эрч хүч амтагдаж, оргилж яваа, сайхан нас. Монголын Эмнести Интернэшнлийн хувьд ч үйл ажиллагаа нь тогтворжиж, өөрийн гэсэн хуримтлуулсан туршлагатай, олон улсын болон дотоодын хамтран түншлэгчид болоод гишүүд дэмжигчид олонтой, өргөн цар хүрээтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Гэвч дэлхий ертөнцөд тэгш бус байдал нэмэгдэж, уур амьсгал хурдтайгаар өөрчлөгдөж, таньж мэдэхгүй технологи хүмүүсийн амьдралд хүч түрэн орж ирж, дэлхий дахины байдал хэзээ хэзээнээсээ илүү ярвигтай болж байна. Энэ цаг үед өөрсдийн ашиг сонирхлын төлөө ажилладаг дарангуйлагч удирдагчид олширч байгааг бид харж байна.

Тиймээс бид хэзээ хэзээнээсээ илүүтэйгээр бат зогсож, биднийг бүчин ирэх асуудлыг хамтдаа, эв санаа нэгтэйгээр даван туулж чадна.

Бид хамтдаа ажиллах арга барилаа сайжруулж, итгэлцлийг бэхжүүлж, хамтын ажиллагаа нэмэгдүүлж байж хүний эрхийн асуудлаар илүү хүчтэй ажиллаж чадна. Хүний эрх хэмээх эрхэм нандин суурь үнэт зүйлсээ хамгаалж чадна.

Суурь үнэт зүйл, хүний эрхийн төлөө Монголын Эмнести Интернэшнлийн зориулсан 25 жилийн ойг **тэмдэглэж хамтдаа хундага өргөцгөөе**. Хундага өргөх нь зөвхөн баярын үйл ажиллагаа биш, хүний эрхийг хүндлэх, хамгаалах, хангах үүргээ биелүүлэхгүй байгаа засгийн газруудыг шахах кампанит ажлаа цаашид явуулсаар байх бидний амлалт юм.

Эрх чөлөөний төлөө хундагаа өргөцгөөе.

МЭИ-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ГАНЧИМЭГ

БИ дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөний нэг хэсэг болох Монголын Эмнести Интернэшнл байгууллагад анх Хуульчдын бүлгийн гишүүн, улмаар Гүйцэтгэх Товчоонд хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнаар орж байснаа дурсахад таатай байна. Эмнести Интернэшнл Монгол улсад хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулаад ямар ололт амжилт гаргасан юм бэ гэж маш олон хүн надаас асуудаг. Бидний 25 жилийн хугацаанд гаргасан амжилт, үр нөлөөг дурдаад барахгүй ч миний хувьд өнөөдөр та бүхэнд багцлаад 3 зүйлийг онцолж хэлмээр байна.

Нэгдүгээрт Монгол улсад хүний эрхийг түгээн дэлгэрүүлэхэд Монголын Эмнести Интернэшнл томоохон хувь нэмэр оруулсан

Жил бүр бид шог зураг, гэрэл зураг, зурагт хуудасны үзэсгэлэн гээд олон арга хэмжээ зохион байгуулж, хэдэн арван хүний эрхийн гарын авлага, ном товхимол, судалгааны материал хэвлэн гаргаж, хүний эрхийн боловсрол олгох, хандлага өөрчлөх сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулдаг.

Одоогоор хүний эрхийн боловсролын асуудлаар Онол практикийн бага хурал, форумыг тогтмол, Эрхээ мэдье мэтгэлцээнийг орон даяар тогтмол, "Хүний эрх философийн уулзварт" олимпиадыг тогтмол зохион байгуулдаг болсноос гадна, энэ чиглэлд хамтарч ажилладаг түнш байгууллагуудын хүрээ жилээс жилд улам бүр өсөн нэмэгдэж байна. Хүний эрхэд ээлтэй сургууль, хүний эрхийг нэгж хичээлээр олгох нь ур чадварын уралдаан гээд үйл ажиллагаа бүр тогтвортой, жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг болсон байна.

Хүний эрхийн боловсролын асуудал Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрт тусгалаа олоход бид чамгүй хүчин чармайлт гаргаж, хувь нэмрээ оруулж ажилласан.

Хоёрдугаарт өнгөрсөн 25 жилийн туршид Монгол улсын эрх зүйг хөгжүүлэхэд Монголын Эмнести Интернэшнл хувь нэмрээ оруулсан

Монголын Эмнести Интернэшнлийн зөвлөмж, уриалга, шаардлага, нөлөөллийн ажлын үр дүнд Монгол улс өнөөдөр Байнгын ажиллагаатай Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, Иргэний болон улс төрийн эрийн тухай олон улсын пактын 2-р нэмэлт протокол, Галт зэвсэгийг хяналттай байлгах Зэвсэгийн худалдааны гэрээзэрэг олон улсын хүний эрхийн хэм хэмжээний баримт бичгүүдэд нэгдэж орсон бөгөөд үндэсний хууль тогтоомжийг эдгээр гэрээ, конвенцид нийцүүлж байна. 2017 онд Монгол улс Эрүүгийн хуулиасаа цаазаар авах ялыг хасч, энэ ялыг бүрэн халсан дэлхийн 105 дахь улс болсон. Шударгаар шүүлгэх эрх, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн хэрэгжилтийг шаардсан Монголын Эмнести Интернэшнлийн дуу хоолой, ТББ-уудын хамтын ажиллагаа хууль эрх зүйн орчин болоод практикт тогтсон буруу жишгийг арилгахад хувь нэмрээ багагүй оруулсан.

Гуравдугаарт хүмүүс бол хүч хүмүүс бидэнтэй байгаа цагт бид хүчтэй буюу Монгол дахь идэвхитэй, оролцоотой иргэн бий болох, иргэний нийгмийн хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсан

Социализмын үеэс уламжилж ирсэн ҮЭ, Эмэгтэйчүүд, Монголын Оюутны болон Залуучуудын холбоог эс тооцвол Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа гишүүнчлэлтэй цөөхөн ТББ-ын нэг нь Монголын Эмнести Интернэшнл бөгөөд долоон мянган гишүүд дэмжигчдийг эгнээндээ нэгтгээд байна. Хүмүүсийг, хамтрагч байгууллагуудаа Эмнести Интернэшнлийн зорилго, үнэт зүйлдээ нэгтгэж чаддагт бидний хүч оршдог. Ялангуяа сүүлийн 10 гаруй жил Монголын Эмнести Интернэшнл залуучуудыг хүний эрхийн асуудлаар үгээ хэлж, үйл ажиллагаа өрнүүлдэг болгоход гол анхаарлаа чиглүүлэн ажилласан. Энэ зүтгэл маань талаар болоогүй. Харин ч энэ цаг үед хүний эрхийн үнэт зүйлийг тууштай хамгаалахад залуучууд манлайлан ажиллаж байгааг харахад таатай байна. Хүмүүсийг, залуучуудыг үйл ажиллагаандаа татаж оролцуулдаг, тэдэнд хүсэж буй өөрчлөлтөө өөрийн гараар бүтээх боломж олгодог орон зайг Монголын Эмнести Интернэшнл бий болгосон.

Мэдээж энэ бүх ололт амжилт ганц өдөр ирээгүй. Энэ бол 25 жилийн турш буюу нийт 9125 өдөр нэг нэгээр нь уйгагүй, шантралгүй бүтээсэн Монголын Эмнести Интернэшнлийн үе үеийн гишүүд, дэмжигчид, Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх товчооны ажилтнууд, сайн дурынхан болоод бидний түнш хамтран зүтгэгч та бүхний оролцоо, хувь нэмэр, дэмжлэгээр бүтсэн ололт амжилт билээ.

Хорин таван жилийн туршид бидэнтэй хамт байгаа та бүхэнд гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

Монголын Эмнести Интернэшнлийн 25 жилийн ойд зориулж Гүйцэтгэх захирал Б.Алтантуяагийн хэлсэн үг

БИРМ ДЭХ УЗЭЛ & САНАЛЫН ХОРИГДЛЫГ СУЛЛА!
BRAVE
ОЛОН УЛСЫН ЭРЧҮҮГИЙН ШҮҮХ
MY BODY MY RIGHT
ЭМНЕСТИ ХАРЖ БАЙНА
STOP TORTURE
(DEMAND DIGNITY)
ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭ ЗОГСОО
ЭРҮҮ ШҮҮЛТ
ТӨРҮҮРГЭЭ МЭД БИЕЛҮҮЛ
ЦААЗЫН ЯЛГУУ МОНГОЛ УЛС


НЭГ ХҮНИЙ АМЬ ИЭГ ГАРЫН ҮСЭГ
MONGOLIA BRAVE EDIT
ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАЧЫГ ХАМГААЛАХ НЬ
AMNESTY
ЭРХЭЭ ДАРХЛААНУУЛЬЯ
ХҮНИЙ ЭРХЭЭ ЭЛАТЭЙ СУРГУУЛЬ
ХҮНИЙ ЭРХИЙН БАЛАНСЫГ ХУН БИРТ
WIRE
ЭРГҮЛ
ХҮНИЙЭРХ
ЭРХЭЭ МЭДЬЕ
ЗАЛУУЧУУД ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨ
ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ
ХҮНИЙГ ХАМГААЛ
Технологи ба соёлын эрх-эх хэл
МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ XX ЧУУЛГАН
STOP VIOLENCE
ХҮНИЙГ ХУНДАЛ

ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЭСРЭГ

АСУУДАЛ

2019 онд дэлхий дахинаа цаазаар авах ял гүйцэтгэх нь 2018 онтой харьцуулахад 5% -иар буурсан нь сүүлийн 10 жилд бүртгэгдсэн хамгийн бага үзүүлэлт бөгөөд энэ нь 2015 оноос хойш жил бүр багассаар байна. Үүнд Египет, Япон, Сингапур зэрэг улсад цаазаар авах ялын гүйцэтгэл багассан нь нөлөөлжээ.

АНУ-д Нью Хампшир бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан 21 дэх муж улс болж, цаазаар авах ял сонссон хамгийн олон хоригдолтой Калифорни мужийн амбан захирагч ялын гүйцэтгэлд моратори зарлажээ.

2019 онд дэлхий дахинд цаазаар авах ялыг халсан улс бүртгэгдээгүй ч хадгалж үлдэх хүсэлтэй улс орны тоо багассан эерэг шинж тэмдэг ажиглагдсан.

Казахстан, ОХУ, Тажикстан, Малайз, Гамби улс албан ёсоор цаазаар авах ялын гүйцэтгэлийг түдгэлзүүлсэн хэвээр үлдэж, Барбадос Үндсэн хуулиасаа заавал оногдуулах цаазаар авах ялыг хасч, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Экваторын Гвиней, Гамби, Казахстан, Кени, Зимбабве улсад цаазаар авах ялыг халахад чиглэсэн эерэг өөрчлөлтүүд ажиглагдлаа.

Гэвч Ирак, Саудын Араб, Өмнөд Судан, Йемен зэрэг зарим улс өмнөх онтой харьцуулахад цаазаар авах ялын гүйцэтгэлээ нэмэгдүүлсэн байна. Бахрейн, Бангладеш нэг жил завсарласны эцэст 2019 онд цаазаар авах ял гүйцэтгэж, Филиппиний хууль тогтоогчид цаазаар авах ялыг сэргээх хуулийн төслүүд санаачилжээ. Шри Ланка, АНУ-ын холбооны засгийн газар олон жилийн дараа цаазаар авах ялыг сэргээхийг завдав. Монгол улс Цаазаар авах ялыг халсан байдлаа хэвээр хадгалж үлдлээ.



ЗОРИЛТ

- Олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
- Бусад улс орнуудад цаазаар авах ялыг халахыг уриалсан үйл ажиллагаанд оролцох

Цаазаар авах ял гэмт хэргээс сэргийлэх үр нөлөөгүй болохыг олон нийт, зорилтот бүлэгт таниулах нөлөөллийн болон соён гэгээрүүлэх төрөл бүрийн арга хэмжээг зохион байгууллаа.

Монголын Эмэгтэйчүүдийн Сан, Хүйсийн тэгш эрхийн төв, Хөөрхөн зүрх ТББ, Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын хамтран зохион байгуулсан "**Охидын бэлгийн халдашгүй байдлыг хангахад төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь**" зөвлөлдөх уулзалтад оролцсон төрийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс Бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд илүү өргөн хүрээнд цогц арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгааг анхааруулаа. Уулзалтаас оролцогчдын гаргасан саналуудад үндэслэн зөвлөмж гаргаж, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүллээ.

Кино хэлэлцүүлгээр хүний эрхийн боловсрол олгох, цаазаар авах ялын талаарх дэлхийн чиг хандлагыг илүү олон хүнд түгээх чиглүүлэгч бэлтгэх сургалтыг хүний эрхийн ТББ-ын ажилтан, орон нутгийн идэвхтэн, бүлгийн ахлагч нарт тус бүр 2 болон 3 дугаар сард, оюутан, залуучуудын бүлгийн идэвхтэй гишүүд, дэмжигчдэд 10 болон 11 дүгээр сард тус тус зохион байгуулаа.

Нээлттэй Нийгэм Форумтай хамтран Монголын Эмнести Интернэшнлийн кино хэлэлцүүлэг чиглүүлэгч оюутан залуучууд "Жинхэнэ гэмт хэрэг", "Баяртай Бафана" киногоор 4 дүгээр сард Отгонтэнгэр, Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн оюутнуудад, их дэлгүүрийн Icinema кинотеатрт олон нийтэд, 11 дүгээр сард МУБИС-ийн нийгмийн ажилтны анги, Соёл эрдэм дээд сургууль, Монголын Үндэсний Их сургууль, Дотоод хэргийн их сургуулийн Хилийн сургууль, Батлан хамгаалах их сургуулийн оюутнууд, сонсголын бэрхшээлтэй иргэдийн дунд кино хэлэлцүүлэг өрнүүллээ. Завхан аймаг дахь орон нутгийн бүлгийн гишүүд "Жинхэнэ гэмт хэрэг, Баяртай Бафана" зэрэг киногоор аймаг, сумдын иргэдэд кино хэлэлцүүлэг хийлээ.

Эмнести Интернэшнлээс жил бүр эмхтгэн гаргадаг Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2018 тайланг орчуулан гаргахын зэрэгцээ Өмнөд Судан, Малайз, АНУ, Иран улсад цаазаар авах ялыг халах уриалгад нэгдлээ.

ТОО БАРИМТ

60 орчим кино хэлэлцүүлэг чиглүүлэгчтэй болж, нийт **550** оюутан залуучууд, иргэдэд хүний эрхийн боловсрол олгож, кино хэлэлцүүлэг өрнүүллээ.

Цахим хуудас, сонин бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний хэрэгслээр Цаазаар авах ял ба гүйцэтгэл 2018 тайлан болон бусад холбогдох мэдээ, мэдээллийг **25000** гаруй хүнд хүрлээ.

5 улсад цаазаар авах ялыг халах уриалгад нэгдэж **3000** гаруй гарын үсэг цуглуулж эв санааны нэгдлээ илэрхийллээ.

«ЗОРИГТОН» ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙГ ХАМГААЛАХ НЬ

АСУУДАЛ

Засгийн газар, корпорацууд эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж байгааг эсэргүүцэж, хүрээлэн буй орчин, цөөнхийг хамгаалж, эмэгтэйчүүд, ЛГБТИ хүмүүсийн эрхийн талаарх уламжлалт саад тотгор, авилгал, хөдөлмөрийн мөлжлөгийн эсрэг тэмцдэг хүний эрхийн хамгаалагчид нийгмийн бүхий л давхаргыг төлөөлдөг. Сэтгүүлч, байгаль хамгаалагч, малчин, орон нутгийн иргэд, өмгөөлөгч, хүний эрхийн зөрчлийн хохирогч, шүгэл үлээгч, оюутан залуус, эмч, багш гэвч хэн ч байж болно. Шударга бус явдал, ялгаварлан гадуурхалт, хүний эрхийн зөрчилтэй үл эвлэрснийх нь төлөө үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран чуулах эрхэд нь халдаж байна.

1998 онд Олон улсын хамтын нийгэмлэг "Хүний эрхийн хамгаалагчид болон иргэний нийгмийг хамгаалах тухай тунхаглал"-ыг зөвшилцөн баталснаас хойш аль хэдийн 20 жил өнгөрчээ. Энэ тунхаглалаар тэд хүний эрхийн хамгаалагчдыг дэмжиж, аливаа саад тотгор, айдасгүйгээр үйл ажиллагаа явуулах боломжоор хангана гэж амалсан. Гэвч өнөөдөр энэ үзэл санаа, заалт Монгол улсад илт зөрчигдөж, хүний эрхийн хамгаалагчдад илүү эрсдэлтэй хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлж, гадаадаас санхүүжилт авахыг хориглох зэргээр хүний эрхийн төлөө тэмцэх орон зайг хумихыг санаархаж байна. Төр гуравдагч этгээдийн зүгээс хүний эрх хамгаалагчид руу халдаж байгаа халдлагыг үр дүнтэй мөрдөн шалгаж, таслан зогсоож чадахгүй байна.

ЗОРИЛТ

- **Хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрүүлэх, айдасгүй, аюулгүйгээр шударга бусын эсрэг тэмцэх эрх зүйн орчин бий болгох**
- **Хүний эрх хамгаалагч, иргэний нийгэм, идэвхтнүүдийн эрхийг хязгаарласан хууль тогтоомжийг халах асуудлаар дэлхийн кампанит ажил өрнүүлэх,**
- **Хүн бүр хүний эрхийг дээдэлдэг дэлхий ертөнцийг бүтээхэд залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлж, хүний эрх хамгаалагчдын сүлжээг дэмжих**

Монгол улсад хүний эрх хамгаалагчийг хамгаалах, шударга ёсны төлөө дуугарч буй хүн бүр айдасгүй, аюулгүй орчинд үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлдэг байх хууль эрх зүйн орчныг бий болгохыг зорьж хүний эрхийн төрийн бус байгууллагууд, Хүний эрхийн үндэсний комисс, хуульч, судлаачидтай хамтран Ажлын хэсэгт ажиллаж, төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, хууль тогтоогч нартай нөлөөллийн уулзалтууд зохион байгуулж, оролцов.

Оюу толгой хяналт ТББ-аас 8 дугаар сард зохион байгуулсан "Танигдан хамгаалагдах" сэдэвт хүний эрх хамгаалагчдыг хамгаалах стратегийг төлөвлөх, хамгаалалтын орчныг сайжруулах тухай сургалт семинар, зөвлөлдөх уулзалтад оролцож, Эмнести Интернэшнлийн "Зоригтон" дэлхий дахины кампанит ажлын талаарх мэдээ мэдээллийг бусад иргэний нийгмийн байгууллагуудын идэвхтэн, төрийн байгууллагын төлөөлөлд нарт хүргэлээ.

9 дүгээр сард болсон "**Хүн бүр хүний эрхийн хамгаалагч – эрх зүйн баталгааг хангах нь**" зөвлөлдөх уулзалтын үеэр Хүний эрхийн үндэсний комисс, Японы Хүүхдийг ивээх сантай хамтран хүүхдийн эрх, хүний эрхийн тухай, дэлхий дахины хүний эрх хамгаалагчдын түүх намтрыг харуулсан үзэсгэлэн зохион байгууллаа.

Мөн Нээлттэй Нийгэм Форумтай хамтран хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг идэвхтэн, сэтгүүлч нарт **"Хүний эрх хамгаалагч" кино үдэш** зохион байгуулж, НҮБ-ын Хүний эрхийн хамгаалагчийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Мишель Форстыг урьж дэлхий дахинаа хүний эрх хамгаалагч нарт тулгарч буй бэрхшээл, сорилын талаар асуулт хариулт явуулж, оролцсон сэтгүүлчид, хуульчид, цахим идэвхтнүүд үзэл бодлоо илэрхийлснийхээ төлөө дарамт шахалттай нүүр тулж, Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйл буюу гүтгэх заалтаар шүүхэд дуудагдсан тухай мэдээллээ. Нээлттэй Нийгэм Форумтай хамтран их дэлгүүрийн Icinemaд "Сельма" киногоор хэлэлцүүлэг хийлээ.

НҮБ-ын Тусгай илтгэгч ноён Мишель Форст Монгол Улсад 2019 оны 4 дүгээр сарын 30-наас 5 дугаар сарын 13-нд ажиллаж, гаргасан тайландаа МУ-ын Засгийн газарт хүний эрх хамгаалагчдын эрхийг хамгаалах бодлого, стратеги боловсруулахдаа баримтлах 7 зарчмыг удирдлага болгохыг зөвлөж, мөн эмэгтэй хүний эрх хамгаалагчид, бэлгийн цөөнхийн эрхийг хамгаалагчид болон бусад хүний эрх хамгаалагчдын эсрэг зөрчил, хүчирхийлэл болон халдлга дайралтын хэргийг үр дүнтэй мөрдөж, яллахаас гадна эрхийг сэргээх, интернет болон бусад бүх орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой үндэсний хууль тогтоомжоо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакттай нийцүүлэх, ТББ-ын тухай хуульд оруулах аливаа өөрчлөлтийг олон улсын хэм хэмжээтэй нийцүүлэх, хүний эрхийг хамгаалагчдын Монгол Улсад гүйцэтгэж буй үүрэг, ач холбогдол ба хууль ёсны эрхийг олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх, хамгаалагчдыг айлган сүрдүүлэг, мөрдлөг хавчлага болон хүчирхийллээс ангид байлгаж, төрийн бодлого, хууль тогтоомжийн шийдвэр гаргах үйл явцад оролцуулах зэргээр олон зөвлөмжийг хүргүүлжээ.

ТОО БАРИМТ

Хүний эрх хамгаалагчийг хамгаалах нь үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг хэвлэл мэдээлэл, цахим хуудас, нийгмийн сүлжээгээр дамжуулан
66000 **гаруй хүнд хүргэлээ.**

Хүн бүр хүний эрх хамгаалагч байх, ХЭХ-дыг хамгаалах зайлшгүй шаардлагын талаарх кино хэлэлцүүлэг, үзэсгэлэн, бусад үйл ажиллагаанд
500 **хүн хамрагдав.**

24 **залуу хүний эрх хамгаалагч, идэвхтнүүд бэлтгэгдэн гарч, хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа өрнүүллээ.**

Эмнести Интернэшнлийн Зоригтон кампанит ажлын хүрээнд бид 2018 оноос эхлэн дэлхий дахины олон хэл дээрх нэвтэрхий толь болох Википедиад хүний эрх хамгаалагч, идэвхтэн, тэмцэгч нарын түүхийг оруулж эхэлсэн ба 2019 онд Н.Чинчулуун, Ц.Цэнд-Аюуш, М.Чимэддорж, Б.Буянхүү, Б.Нямжав, Р.Лувсансумъяа, Д.Бадамцэцэг зэрэг эмэгтэй хүний эрх хамгаалагчид, иргэний нийгмийн төлөөлөл, Монголын Эмнести Интернэшнлийн идэвхтэн гишүүдийн түүх орлоо.

12-р сарын 10 буюу олон улсын хүний эрхийн өдрийг угтан хүний эрх, эрх чөлөөг хамгаалсныхаа төлөө айлган сүрдүүлэг, дарамт шахалт, халдлага дайралтад өртдөгч, айдас аюул, эрсдлийг умартан өнөөдрийг хүртэл хүний эрхийн төлөө цуцалтгүй тэмцэж яваа хүний эрх хамгаалагчдыг олон нийтэд таниулахаар ЗОРИГТОН хөрөг найруулал бичих уралдаан зарласанб өгөөд уралдаанд оролцсон сэтгүүлч, нийтлэлчид охид, эмэгтэйчүүд, жендэрийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалтын эсрэг, хүн худалдаалах гэмт хэргийг зогсоох, ЛГБТИ хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалагчдын тухай онцлон бичлээ.

2-р сард Архангай аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, 9-р сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран Хөвсгөл аймгийн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчид, сэтгүүлч нарт хүний эрх хамгаалагч, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нь, стратегитэйгээр кампанит ажил өрнүүлэх тухай сургалт зохион байгууллаа.

Хүний эрхийн боловсролоор дамжуулан дангаараа болон бусадтай хамтран хүний эрхийн төлөө тэмцдэг, хүний эрхийн соёлыг түгээн дэлгэрүүлдэг, Эмнести Интернэшнлийн кампанит ажилд манлайлан идэвхтэй оролцдог хүний эрх хамгаалагч залуучуудыг бэлтгэх зуны сургалт зохион

байгуулав. Сургалтанд хамрагдсан хүүхдүүд Sweet september, кино хэлэлцүүлэг, олон улсын хүний эрхийн өдөр, эрхийнхээ төлөө бичицгээе үйл ажиллагааг зохион байгууллаа.

12-р сарын 9-10 буюу Олон улсын хүний эрхийн өдрөөр хүний эрхийн ТББ-ын Форум, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран иргэний нийгмийн мэдээллийн зах арга хэмжээнд оролцож, "Эрхийнхээ төлөө нэгдэцгээе" арга хэмжээг Улсын дуурь бүжгийн эрдмийн театрт хамтран зохион байгуулав.

Монголын Эмнести Интернэшнлийн 25 жилийн ойг тохиолдуулан "Хүний эрх, эрх чөлөө" сэдэвт шог зургийн үзэсгэлэн зохион байгууллаа. 2019 оны 12-р сарын 10-17-ны хооронд Монголын Уран зургийн галерейд дэлгэгдэж байгаа тус үзэсгэлэнд олны танил Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Ц.Байды, Соёлын гавьяат зүтгэлтэн шог зураач С.Цогтбаяр болон шог зураач С.Алтангэрэл, Ц.Намжилдорж, Л.Өлзийбат, Д.Гансүх, А.Бат-Эрдэнэ, А.Амарсайхан, М.Амархүү, Ч.Цэцэгдарь, С.Болд, доктор М.Моломжамц нарын 100 гаруй бүтээл тавигдлаа.

Ираны эмэгтэй хүний эрх хамгаалагч Насриныг суллуулах уриалгад оюутнууд болон Монголын Эмнести Интернэшнлийн Ерөнхий Чуулганы оролцогчид нэгдлээ.

ЭРҮҮДЭН ШҮҮХИЙГ ЗОГСООЁ

АСУУДАЛ

Монгол Улс бүх гэмт хэрэгт цаазаар авах ялыг халсан Эрүүгийн хууль(шинэчилсэн найруулга), эрүүдэн шүүхийг, эрүүдэн шүүж авсан мэдүүлгийг шүүх ажиллагаанд нотлох баримт болгож ашиглахыг илт хориглосон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) баталж, хэрэгжүүлж байгаа нь амьд явах, эрүү шүүлт, зүй бус харьцаанаас ангид байх эрхийн биелэлтийг хангах бодит алхам боллоо. Гэхдээ Монгол Улсын хувьд олон улсын хүний эрхийн хууль, хэм хэмжээнд хууль, тогтоомжоо нийцүүлэн, сайжруулах шаардлагатай олон ажил хүлээгдэж байна.

Монгол Улсын Засгийн газар нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг, Хүний эрхийн хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, Эрүүдэн шүүхийн асуудлаарх Тусгай илтгэгчээс эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус харьцах явдалтай тэмцэх, буруутай этгээдийг шийтгэх, хараат бус мөрдөн байцаах албаа чадавхжуулах талаар зөвлөмж хүлээн авч, тэдгээрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

2019 оны 3 дугаар сард Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдорж С.Зоригийн амь насыг хохироосон хэрэгт сэжиглэгдэгсдэд хэрэг хүлээлгэхийн тулд эрүү шүүлт хэрэглэснийг хүлээн зөвшөөрч, уучлал гуйсан нь Монгол улсад эрүү шүүлт оршин тогтносоор байгааг харууллаа.

Монгол Улс өнгөрсөн хугацаанд өмнөх хүний эрхийн амжилтаасаа ухарсан үйлдэл гаргаж Монгол Улсын Их Хурлаас Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Прокурорын тухай хууль, Авлигын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар шүүхийн хараат бус байдлыг дордуулж байгаад Монголын Эмнести Интернэшнл харамсаж байна. Түүнчлэн Засгийн газраас эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцааны хохирогч болсон хүмүүсийн хөндөгдсөн эрхээ бүрэн нөхөн сэргээлгэх, хохирлоо нөхөн төлүүлөх механизмыг байгуулсангүй.

ЗОРИЛТ

Монгол улсад Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколын дагуу үр нөлөө бүхий Үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгуулахыг уриалах

Монголын Эмнести Интернэшнлээс Монгол Улс эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэн сахих үүргээ биелүүлэхийг шаардсан мэдэгдлүүд гаргалаа. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, түүнийг дагасан бусад хуулийн төслийн зохицуулалт нь эрүүдэн шүүхтэй тэмцэхээс илүүтэйгээр шударгаар шүүлгэх эрхийн баталгааг үгүйсгэж, шүүх тогтолцооны хараат бус байдлыг алдагдуулан, эрүүдэн шүүх гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг улам хүндрүүлэх эрсдэлтэй байгааг дурдаж, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг хангах, эрүүдэн шүүх гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах албыг байгуулж, эрүү шүүлтээс Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизм бий болгохыг уриаллаа.

Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг нь таниулах, чадавх бэхжүүлэх, сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж, бэлтгэгдсэн сургагч багш нар Отгонтэнгэр их сургууль, Монголын Үндэсний их сургууль, Шихихутуг хууль зүйн их сургуулийн оюутнуудад кино хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрийг угтан залуучуудын дунд "Эрүү шүүлтийн эсрэг эрүүл шүүмж" шог зургийн уралдаан зарлаж, 6 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монголын Үндэсний музей дээр гаргалаа.

Монголын Эмнести Интернэшнлээс Эрүүдэн шүүхийн хохирогчдод туслах олон улсын өдрөөр УИХ-ын Хүний эрхийн байнгын хороо, Фрейдрих Эбертийн сан, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран "Эрүүдэн шүүхийн хохирогчдын эрхийн асуудал" сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар хэлэлцэж, хохирогчдын дуу хоолойг сонслоо. УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Н.Оюундарь хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ "*Монгол улс 2014 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт, протоколыг соёрхон баталж, хүчин төгөлдөр үйлчилж байна. Протоколд нэгдэж орсноос хойш нэг жилийн дотор оролцогч улс үндэсний түвшинд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх байгууллагыг байгуулж, томилгоог шийдвэрлэсэн байх үүрэгтэй бөгөөд хангалттай төсөв, хүний нөөцтэй, үйл ажиллагаа нь хараат бус, бие даасан статус бүхий эрүү шүүлтийн эсрэг байгууллагыг байгуулах ёстой. Харамсалтай нь энэ шаардлагыг*



одоо болтол манай улс биелүүлээгүй байна" гэдгийг онцолжээ. Мөн нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон иргэд, хохирогчдын ар гэрийнхэн, хорих анги болон цагдаагийн газарт эрүү шүүлтэд өртсөн тухай ярьсан бол, өмгөөлөгчид цагдан хорих, таслан шийдвэрлэх арга хэмжээтэй холбоотой нөхцөл байдлын талаар шүүмжилж, нөхцөл байдлын талаар тодорхой жишээ баримтуудыг дурдаад холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах шаардлага байгаа ба мөн Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албыг нэн даруй дахин байгуулах шаардлагатай байгааг дурдав.

Нээлттэй Нийгэм Форумтай хамтран "Баяртай Бафана" киногоор их дэлгүүрийн Icinema-д кино хэлэлцүүлэг зохион байгуулж, Увс аймгийн цэргийн ангийнханд "Төмөр хошуут сахиусан тэнгэрүүд" киногоор хэлэлцүүлэг хийж, иргэд олон нийт, зорилтот бүлгийн хүний эрх, хүний эрх хамгаалагч, эрүүдэн шүүхээс ангид байх эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэв.

Дэлхий даяар өрнөсөн Хонконгийн сэжигтэн, ялтан шилжүүлэх тухай хуулийн төслийг эсэргүүцсэн үйл ажиллагаанд МЭИ-ийн оюутан залуучууд, гишүүд дэмжигчид нэгдлээ. Уг хуулийн төслийг эсэргүүцсэн Хонконгийн 2 сая орчим иргэд гудамж талбайд гарч жагсан, дэлхийн өнцөг булан бүрээс шаардлага хүргүүлснээр 2019 оны 9 дүгээр сард тус нутаг дэвсгэрийн засаг захиргаанаас уг хуулийн төслийг буцаан татжээ. Оюутан залуучууд мөн эв санааны нэгдлээ илэрхийлсэн уриалгад нэгдлээ.

ТОО БАРИМТ

Эрүүдэн шүүхээс ангид байх эрхтэй холбоотой мэдээ мэдээлэл, видеог нийгмийн сүлжээгээр дамжуулан

122 216 хүнд хүргэлээ.

Оюутан залуучууд мөн эв санааны нэгдлээ илэрхийлсэн уриалгад нэгдлээ.

Эрүүдэн шүүхийн эсрэг үйл ажиллагаанд нийт

1200 орчим хүн биечлэн оролцлоо.

47 сургагч багш бэлтгэгдлээ

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

АСУУДАЛ

Эмнести Интернэшнл хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн зөрчлийн үндсэн шалтгааныг тогтоох, урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхалтай тэмцэх, эрх тэгш байдлыг хангах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэж үздэг.

Нийгмийн харилцаанд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө бодитой эдэлж чадахуйц мэдлэг, чадвар Монголчуудад байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор үндэсний хэмжээнд судалгааны ажлууд хэд хэдэн удаа хийгдсэн байдаг. Эдгээр судалгааны үр дүн, гарч буй санал зөвлөмжүүд нь Монгол улс дахь хүний эрхийн боловсролын түвшин хангалтгүй, энэ чиглэлээр тодорхой бодлого боловсруулан ажиллах шаардлагатайг харуулдаг.

Эдгээр судалгаанаас харахад Монголчууд хүний эрхийн боловсролын ач холбогдлыг ойлгож байгаа боловч амьдрал дээр хэрхэн өөрийн эрх, эрх чөлөөг хамгаалах, аливаа зөрчил, эрсдэлээс хэрхэн хамгаалах талаар цогц ойлголт, мэдлэг мэдээлэлгүй байна. Мөн хүний эрхийн аливаа зөрчлүүд нь ихээхэн ужгирч, хүнд хэлбэрт орсны дараа л хэвлэл мэдээллийн болоод олон нийтийн анхаарлын төвд ордог, гэвч тэдгээрийг шийдвэрлэж буй арга хэмжээ нь үр дүнгүй, хүний эрхийн мэдрэмжгүй байх нь түгээмэл байна.

Энэ нь Монгол улсад албан ба албан бус байдлаар олгож буй хүний эрхийн боловсрол сургалтын үйл ажиллагаа системчлэгдээгүй, үр дүн муутай, мөн хүний эрхийн боловсролын чиглэлээр төрийн нэгдсэн бодлого байхгүй явж ирсэнтэй холбоотой юм. Нөгөө талаас төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцоо, үүсгэл санаачлага дутмаг, нийгэмд хүний эрхийн соёл хараахан төлөвшиж амжаагүй байна.

НҮБ-ын Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн гурван үе шат (2005-2009, 2010-2014, 2015-2019)-ны хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэхэд Монголын Эмнести Интернэшнл анхаарч 15 гаруй жилийн турш хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөртэй болох талаар нөлөөллийн ажил хийлээ. Үүний үр дүнд "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөр" батлагдаж, хөтөлбөрийн хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын санаачилгаар эрх зүйн хөтөч бэлтгэж, www.ekhutuch.mn, Хууль зүйн луужин 1 (Facebook page) болон ILAW апплекэйшн зэрэг албан мэдээллийн суваг, 1800-1202, 7000-1982 зэрэг хууль, эрх зүйн лавлах утас ажиллуулдаг болсон нь хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх илүү боломжтой болгож байна.

ЗОРИЛТ

- Гишүүд, дэмжигчид, малчид, иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтэд сургалт, хэлэлцүүлэг хийн чадавхжуулах,
- Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөрийн сургуулиудыг дэмжих, хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх
- Төрөл бүрийн салбарт түншлэл тогтоох, тэднийг хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд татан оролцуулах

2019 он бүхэлдээ хүний эрхийн боловсролыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэн нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, дүүрэг, хороо, хөдөө орон нутгийн иргэд, малчид, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод зэрэг иргэний нийгмийн байгууллагуудад хүрч ажилласан, хамтарч үйл ажиллагаа зохион байгуулсан жил байлаа.

ЭРХ ЭДЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХЫН ТӨЛӨӨ

Эмнести Интернэшнлийн хүний эрхийн сургалтаар мэдлэг, мэдээлэлтэй болсон гишүүд, дэмжигчид, малчид, нөлөөлөлд өртсөн иргэд эрхээ шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх талаар холбогдох төрийн байгууллагуудад өргөдөл, гомдол гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандан үгээ хэлэх, ярилцлага өгөх, эвлэлдэн нэгдэж үйл ажиллагаа зохион байгуулах зэргээр өөрийн болон бусдын эрхийг хамгаалахын төлөө дуу хоолойгоо өргөдөг, хамтарч ажилладаг болжээ.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Монголын Эмнести Интернэшнлээс санаачлан бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан олон ажил тэр дундаа 2013-2018 онуудад зохион байгуулсан Хүний эрхийн боловсролын форумын үр дүнд ХЭҮК УИХ-д өргөн барьсан "Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 18 дахь илтгэл"-ийн Нэгдүгээр бүлэгтээ "Хүний эрхийн боловсрол"-ын өнөөгийн нөхцөл байдлын талаар илтгэсэн. Үүний мөрөөр УИХ-ын 62-р тогтоолоор "Хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжих талаар" арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон нь зайлшгүй биелэгдэх шинжтэй бөгөөд хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд нэгэн том алхам болов.

Эмнести Интернэшнлийн брэнд болсон "Хүний эрх философийн уулзварт" философийн олимпиад, "Эрхээ мэдье" мэтгэлцээн, "Хүний эрхийг нэгж хичээлээр заах нь" багш нарын ур чадварын уралдаан, "Намайг сонс" богино илтгэл, ишлэлийн уралдаан зэрэг уламжлалт уралдаан, тэмцээнүүдээр дамжуулан хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй хийлээ. Оюутан, сурагч, багш, нийгмийн ажилтнуудад зориулсан хүний эрхийн агуулгыг хэрхэн ойлгох, хүний эрхэд суурилсан хандлага гэх зэрэг цогц сургалт, хэлэлцүүлгийг удаа дараа хамтрагч байгууллагуудтайгаа зохион байгуулаа. Уралдаан, тэмцээнд оролцогчид хүний эрхийг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулахаар бидэнтэй хамтарч ажилладаг боллоо.

ТОО БАРИМТ

ХЭЭС-ийн хүрээнд
9800 гаруй хүнд хүрч ажиллав.

Чадавх бэхжүүлэх сургалтад
2860 хүнийг хамруулаа.

Үйл ажиллагаанд давхардсан тоогоор
46075 хүнд хүрснээс 55 хувь нь хүүхэд залуус, 70 гаруй хувь нь эмэгтэйчүүд байв.

Шоглох, дээрэлхэх, дарамтлахын эсрэг нөхөрсөг жаалууд буюу «Тэнцэтгэлийг өөрчилье» сургалтад нийт
970 хүүхэд хамрагдаж, 85 багш хамтран ажиллав. Үе тэнгийн 30 сургагч багш шинээр бэлтгэлээ.

- Мэтгэлцээнд 125 багш хүүхдүүдээ бэлтгэж, 125 багийн 375 сурагч оролцов. 49 сурагч илтгэх урлагийн тэмцээнд оюун ухаанаа сорьлоо.
- Мэтгэлцээнд Отгонтэнгэр Их сургууль, Монголын Карл Попперын мэтгэлцээний нийгэмлэг хамтран ажиллаж, нийт 12 сая гаруй төгрөгийн бэлэн бус хандив өглөө.
- Мэтгэлцээний тэмцээний үеэр оролцогчид уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Грета охины Баасан гарагийн хөдөлгөөнд нэгдэж, эв санааны нэгдлээ илэрхийлсэн.

Философи-хүний эрхийн уулзварт XI олимпиадыг **"Экологийн ёс зүй"** сэдвээр зохион байгуулж, 12 их, дээд сургуулийн 60 оюутан өрсөлдсөн. ХААИС олимпиадын ерөнхий зохион байгуулагчаар ажилласнаар хамтрагч байгууллагын тоо нэмэгдлээ.

"Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь" багш нарын ур чадварын уралдааныг ХЭЭС хөтөлбөрийн сургуулиудын дунд зохион байгуулж, 4-р сургууль хамтрагчаар ажилласан.

ХЭЭС хөтөлбөрийн 14 сургуулийн 21 багш 10 төрлийн хичээлд хүний эрхийг нэгтгэн зааж өрсөлдөв.

4-р сургуулийн 4-11 дүгээр ангийн 405 гаруй сурагчид хүний эрхийн агуулгатай хичээл хүргэжээ.

Хөвсгөл аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчид, иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагынханд зориулсан 2 өдрийн сургалтыг тус тус зохион байгуулж, кино хэлэлцүүлэг хийсэн. Нийт 60 гаруй хүн оролцов.

ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ СУРГУУЛЬ (ХЭЭС) ХӨТӨЛБӨРИЙН СУРГУУЛИУДЫГ ДЭМЖИЖ, ХӨТӨЛБӨРИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ

Хүний эрхэд ээлтэй сургууль хөтөлбөр нь сургуулийн удирдлага, харилцаа, сургалтын хөтөлбөр/хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон сургуулийн орчин зэрэг сургуулийн бүх үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн бодлого, дүрэм, журам гаргаж, хамтаараа хэрэгжүүлснээр хүний эрхийн соёл, хандлага төлөвшүүлэх зорилготой юм.

2019 он бүхэлдээ хүний эрхийн уралдаан тэмцээн, хурал уулзалт, сургалт хэлэлцүүлгээр хүний эрхийн боловсролыг түгээсэн, хамтрагчдаа нэмэгдүүлсэн, ХЭЭС хөтөлбөрийн үзэл санааг ерөнхий боловсролын салбарт танилцуулсан, ХЭЭС хөтөлбөрийн сургуулиуд харилцан туршлага солилцсон, хөтөлбөртөө 4 сургуулийг нэгтгэсэн жил байлаа.

ХЭЭС хөтөлбөрийн сургуулиудын удирдах ажилтны уулзалт хийж, туршлага судлах боломж олгов.

- Шинэ эрин сургуулиар зочилж, туршлага судлах уулзалт хийв.
- ХЭЭС хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх сургагч багшийн сургалт хийж, Сүхбаатар, Дорноговь, Баян-Өлгий, Завхан, Архангай аймаг болон Нийслэл 36 багш оролцов. ХЭЭС хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сайн туршлагуудаас суралцлаа.
- ХЭЭС хөтөлбөрт нэгдэж Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан 4, 12, Логарифм, Улаанбаатар Эмпати сургуулиудыг дэмжин, холбогдох сургалтуудыг зохион байгууллаа.

ХЭЭС хөтөлбөрийн сургуулиудыг "Эрхээ мэдье" мэтгэлцээний болон илтгэлийн тэмцээн, "Нөхөрсөг жаалууд буюу Тэнцэтгэлийг өөрчилье" сургалт, "Эрхийнхээ төлөө бичицгээе", Футболканы өдөр, Ур чадварын уралдаан, Шог зургийн үзэсгэлэн зэрэг хүний эрхийн төлөөх үйл ажиллагаанд урьж оролцуулан идэвхижүүллэв.

ШОГЛОЖ ДАРАМТЛАХЫН ЭСРЭГ НӨХӨРСӨГ ЖААЛУУД БУЮУ «ТЭНЦЭТГЭЛИЙГ ӨӨРЧИЛЬЕ» СУРГАЛТ

Бусдын ялгаатай байдлыг ойлгож, хүндлэх соёл бий болгох зорилготой шоглох, дарамтлах, гадуурхахын эсрэг сурагчид, өсвөр насны хүүхдүүдэд зориулсан "Тэнцэтгэлийг өөрчилье" сургалтыг явуулах үе тэнгийн 30 гаруй сургагч багш бэлтгэлээ. Оролцооны аргаар явагддаг тус сургалт 1-3 анги, 4-5 анги, 6-8 анги, 9-10 анги, 11-12 анги гэсэн 5 модультай болов.

Завхан аймгийн Улиастай хотын ерөнхий боловсролын 4 сургуулийн сургалтын менежер, багш болон аймгийн хүүхдийн удирдах байгууллагын төлөөлөл 10 хүүхдэд "Хүний эрхэд ээлтэй сургууль болох нь" болон "Тэнцэтгэлийг өөрчилье" сургалтаа явуулж, ном гарын авлагаар хангаснаар хүүхдүүд сургалтаа өөрсдөө бие даан хийх боломжтой боллоо.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ЦАХИМААР

Хүний эрхийн боловсролоор дамжуулан та тэгш эрх, нэр хүнд, харилцан хүндлэлийг өөрийн орчин тойронд, нийгэмд, дэлхий дахинаа түгээх ур чадвар хандлагыг өөртөө болон бусдад төлөвшүүлж, хөгжүүлж чадна.

Та www.amnesty.org эсхүл www.amnesty.mn цахим хуудсаар зочилж, "Эрхээ мэдье" хүний эрхийн боловсрол, мэдлэгийн цахим талбараас Эмнести Интернэшнлээс эрхлэн гаргасан хүний эрхийн олон тооны ном товхимол, видео контентыг хүссэнээрээ үзэж судлан өөрийгөө болон бусдыг эрхээ мэддэг, шаарддаг, хамгаалдаг болоход туслах боломжтой.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШЛИЙН 1. ХҮНИЙ ЭРХ

1. Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ?
2. Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь
3. Орон байртай байх эрх гэж юу вэ?
4. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө
5. Сургуулиа хэрхэн хүний эрхэд ээлтэй болгох вэ? зэрэг зайны сургалтуудад хамрагдаж, хүний эрхийн мэдлэг боловсролоо дээшлүүлээрэй. Түүнчлэн, амжилттай суралцан сертификат захиалж авах боломжтой.

ОРОН БАЙРААР ХАНГАГДАХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ

АСУУДАЛ

Хүн бүр шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхтэй. Монгол Улсын хууль тогтоомж, бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд нь Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцээр хамгаалагдсан иргэдийнхээ шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэгтэй.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд иргэдийн шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх ноцтой зөрчигдсөөр байгаа ч зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх хүний эрхэд суурилсан үндэсний механизм сул байна. Үүнээс үүдэн 4-5 жилийн өмнө хоёр болон гурван талт гэрээ байгуулсан ч байрандаа орж чадаагүй, газар, эд хөрөнгөө захиран зарцуулах эрх нь хязгаарлагдсан болон 5-6 жил орон гэргүй яваа иргэдийн гомдол тасрахгүй байна.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хүний эрхийн мэдлэг хомс, төрийн албан хаагчид болон төсөл хэрэгжүүлэгч барилгын компаниуд иргэдийг дахин төлөвлөлтийн талаарх мэдээллээр хангах үүргээ бүрэн, шуурхай биелүүлэхгүй байгаагаас үүдэн иргэд хохирсоор байгаа тул эрхээ мэддэг, хамгаалдаг, шаарддаг соёлыг бий болгох хэрэгцээ их байна.

ХУУЛИЙН ХАМГААЛАЛТ БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ

Орон байртай байх эрхийг хамгаалах "Төр үүргээ мэд, биелүүл" кампанит ажлаараа "Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль" болон түүнийг хэрэгжүүлэх журмуудад олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн

ЗОРИЛТ

- Хүүлийн хамгаалалтыг бий болгохын төлөө
- Эрхээ мэддэг, хамгаалдаг, шаарддаг соёлыг бий болгохын төлөө

хүний эрхийн хамгаалалт бүхий нэмэлт, өөрчлөлт оруулахын төлөө нөлөөллийн ажил, олон нийтийг хамарсан цахим болон цахим бус үйл ажиллагаа, чадавх бэхжүүлэх сургалт, хэлэлцүүлэг, кино хэлэлцүүлэг, Үндэсний дөрвөн талт Зөвлөлдөх уулзалт зэрэг олон ажил зохион байгуулав.

Дахин төлөвлөлтөд өртсөн иргэд, иргэдийн төлөөллийн байгууллагуудыг дэмжин, тэднийг орон байртай байх эрхийг түгээн сурталчлах сургагч багш болгон бэлтгэснээр тэд өөрсдийнхөө болон бусдын төлөө дуугарах, үгээ хэлэх, хамтран ажиллах болсон. Орон байраар хангагдах хүний эрхийн асуудлаар тусгайлан чиглүүлэгч бэлтгэж нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт ажиллав.

Тэд эвлэлдэн нэгдэж, зөрчигдсөн эрхээ шаардах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой идэвхтэй оролцоонд суурилсан дахин төлөвлөлтөд өртсөн иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагуудын Эвсэл болж өргөжин үйл ажиллагаа өрнүүлж байна.

ХЭҮК-ын "Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 17 дахь илтгэл"-ийн Хоёрдугаар бүлэг "Нийслэлийн хот дахин төлөвлөлттэй холбоотой хүний эрхийн зарим асуудал" сэдвээр онцлон гарснийг УИХ хэлэлцэн 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 62 дугаар тогтоолоороо "Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар" анхаарч, арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосон. Зайлшгүй биелэгдэх шинжтэй уг тогтоолыг дахин төлөвлөлтөд өртсөн иргэдэд таниулах, тогтоолын хэрэгжилтийг иргэдээр шаардуулах нөлөөллийн ажил хийлээ. Тухайлбал иргэд ХЭҮК болон ННФ-ын хүний эрхийн асуудлаарх Өглөөний цай уулзалтыг "Орхигдсон иргэд ба дахин төлөвлөлт" сэдвээр зохион байгуулж, "Хот дахин төлөвлөлтийн хохирогч болсон гэр бүл дэх хүүхдүүдийн өөрийн үнэлэмж болон түгшүүрийг судалсан нь" судалгааны тайланг танилцуулав. Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх нь зөрчигдсөнөөс үүдэн хүүхдийн эрх ноцтой зөрчигдсөнийг уг судалгаа харуулж байгаа бөгөөд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг, зорилтот бүлгийн эрх мөн зөрчигдөж байгааг баримт, нотолгоонд суурилан гаргалаа.

Олон улсын хүний эрхийн өдрөөр дахин төлөвлөлтөд өртөн хохирсон иргэдийн талаар богино хэмжээний баримтат кино хийн олон нийтэд түгээсэн нь иргэдийг идэвхжүүлснээр холбогдох байгууллагад гаргах иргэдийн гомдол, нэхэмжлэлийн тоо нэмэгдэв.

Дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх компанитай тохиролцож чадаагүй байхад нь хууль тогтоомжинд зааснаас гадуур хүч, албадлага хэрэглэн нүүлгэсэн хэрэг зэрэг иргэдийн гомдолд үндэслэн олон улсын хүний эрхийн тухай хууль, хэм хэмжээгээр хамгаалагдсан орон байртай байх эрхийг хамгаалах стратегийн өмгөөлөл хийх уулзалтыг хуульчид болон иргэдийн хамтарсан болоод туршлага солилцох уулзалтыг 3 удаа зохион байгуулав.

ЭРХЭЭ МЭДДЭГ, ХАМГААЛДАГ, ШААРДДАГ СОЁЛЫГ БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нээлттэй нийгэм форумын санхүүжилтээр шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалах зорилготой ***"Орон байртай байх эрх (ОББЭ)-Эрх зүйн хөтөч" төслийг*** бид хэрэгжүүлж байна. Бүтэн жилийн турш Завхан, Архангай аймаг болон нийслэлийн 6 дүүрэгт хэрэгжих уг төсөл нь сургалт, хэлэлцүүлэг хийх зэрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зэрэгцээ иргэдийн үндсэн хэрэгцээ, үндсэн эрх болох орон байрных нь асуудлаар хууль зүйн зөвлөгөө, тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилготой. Төслийн хүрээнд Завхан аймагт шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн эрх зүйн хөтөч ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж, эрх зүйн хөтчид зориулсан гарын авлага боловсруулж, НҮБ-ын ОББЭ-ийн шинэчилсэн Мэргэжлийн гарын авлага №21-ийг орчуулж, хэвлүүлэв.

Хөгжилд чиглэсэн аливаа бүтээн байгуулалтын үйл ажиллагаа нь иргэдийнхээ эрхийг ялангуяа шаардлагад нийцсэн орон байраар хангагдах болон өмчтэй байх, эрүүл байх эрхийг зөрчихгүй байх мөн хэнийг ч орон гэргүй болгох ёсгүйг иргэдтэй хамтран төрд сануулсан, холбогдох хууль тогтоомжоо олон улсын хэм хэмжээнд нийцүүлж нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардсан жил байлаа.

ТОО БАРИМТ

ОББЭ-ийн асуудлаарх
60 сургагч багш, чиглүүлэгч

Завхан аймгаас 4 хүн, Архангайгаас 4, Хөвсгөлөөс 2 нийт
34 хүн эрх зүйн хөтөч

Завхан аймагт ОББЭ-Эрх зүйн хөтчийн ажлын байр бэлдлээ.

ЭРСДЭЛД БУЙ ХУВЬ ХҮМҮҮС

АСУУДАЛ

Өнөөдөр дэлхий дахинд эрхээ шаардаж, бусдын эрхийг хамгаалж, шударга ёсны төлөө тэмцэж байгаа эрэгтэй эмэгтэй, хүүхэд гээд олон хүмүүс хүний эрхийн зөрчилд өртсөөр байна.

Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааны гол зүрхэнд эрх нь зөрчигдсөн эрх нь үгүйсгэгдсэн хүмүүс байдаг. Судалгаа хийж, кампанит ажил явуулснаар бид тэдний тэмцэл, түүхэнд гэрэл асааж, амьдралд нь эерэг нөлөө авчирахыг эрмэлздэг. Энэ хүмүүс бол эхчүүд, охидууд хөвгүүд, аав нар юм. Тэд оюутан, малчин, хуульч, хөдөлмөрчин, багш, сувилагч болон бусад олон төрлийн, мэргэжлийн хүмүүс байдаг.

Ердөө юу бодож байгаагаа илэрхийлсэн үзэл санааны хоригдол, засгийн газрын төсөлд зам тавьж өгөхийн тулд орон гэрээ алдах эрсдэлд байгаа иргэд, ор сураггүй болсон гэр бүлийнхнээ хайж байгаа хүмүүс юм. Тэд дан ганцаараа дуугарах нь эрх баригч нарт хүрдэггүй.

Эмнести Интернэшнл шударга ёсыг шаардаж байгаа эрх нь зөрчигдсөн хүн, тэгш бус, шударга бус, худал хуурмагтай нүүр тулж байгаа бусдын төлөө дуу хоолойгоо өргөж байгаа хүмүүстэй хамтдаа үйл ажиллагаа өрнүүлдэг

ЗОРИЛТ

- Эрсдэлд буй хувь хүн, хүний эрх хамгаалагчдыг хамгаалах
- Гишүүд дэмжигчдийг идэвхжүүлэх,

НҮБ-ын Ээлжит Дүгнэлт Хэлэлцүүлэг (ЭДХ) нь улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлын талаарх тайлан илтгэлийг 4 жил тутам хэлэлцдэг бөгөөд хүний эрхийн төрийн бус байгууллагуудаас мөн зэрэгцээ тайлан илтгэлээ илгээдэг.

Монгол улс 2010, 2015 онд хүний эрхийн нөхцөл байдлын тайлангаа НҮБ-ын ЭДХ-ээр хэлэлцүүлсэн бөгөөд тухай бүр Эмнести Интернэшнлээс зэрэгцээ илтгэлийг хүргүүлж ирсэн билээ. Энэ хүрээнд бид 2020 оны 5-р сард болох НҮБ-ын ЭДХ-ийн Ажлын хэсгийн 36 дугаар хуралдаанд хүргүүлэх зэрэгцээ илтгэлээ гаргалаа.

Зүүн Азийн бүсийн төвийн судлаач Дорияан Лау иргэний нийгэм, хүний эрхийн төрийн бус байгууллагууд, хүний эрх хамгаалагч, судлаач, хуульчид болон Хүний эрхийн үндэсний комисстой уулзаж, Монгол улс дахь хүний эрхийн нөхцөл байдлын асуудлаар ярилцлаа.

ЭРХИЙНХЭЭ ТӨЛӨӨ БИЧИЦГЭЭЕ 2019

Эрхийнхээ төлөө бичицгээе 2019 аяны хүрээнд залуучуудын хүний эрхийн боловсрол мэдлэгийг нэмэгдүүлэхээр Монголын Эмнести Интернэшнлийн идэвхитэн оюутан залууст сургалт явуулж, 18 зохицуулагч илгээлээ.

Эрхийнхээ төлөө бичицгээе 2019 үйл ажиллагаанд зориулсан гарын авлага нь улс орнуудад эрх нь зөрчигдсөн хувь хүмүүсийн түүхийг өгүүлэхийн зэрэгцээ, Эмнести Интернэшнлээс дэлхий дахинаа өрнүүлж байсан эрсдэлд буй хувь хүмүүсийн төлөөх захидал уриалгын үр нөлөө амжилтын талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэдэг.

2019 оны 12-р сарын 1-10-ны хооронд үргэлжилсэн Монголын Эмнести Интернэшнлийн Эрхийнхээ төлөө бичицгээе 2019 аяны үеэр гишүүд дэмжигчид Хятад, Иран, Филиппин, Өмнөд Судан, Нигери, Канад, Беларусь, Египет, Мексик, Грек улсад орон байртай байх эрх нь зөрчигдсөн, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалж дуугарсныхаа төлөө олон жилийн хорих ялаар шийтгүүлсэн, эрүүдэн шүүгдсэн, мөнгөн усанд хордсон, сураггүй алга болсон хүмүүсийн хэрэг дээр гарын үсэг цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулаа.

Эрхийнхээ төлөө бичицгээе 2019 аяныг оюутан залуучууд МУИС-ийн ХЗС, ХШУИС, ОУХНУС, ХААИС-ийн Бизнесийн сургууль, АШУИС, Шихихутуг ХЗС, СЭЗИС, Хүмүүнлэгийн Ухааны их сургууль, ЕБС-ийн зарим сургууль дээр зохион байгуулаа. Үүнээс гадна уг аян Архангай, Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Хэнтий, Завхан, Баян-Өлгий аймагт зохион байгуулагдав.

ТОО БАРИМТ

Нийгмийн сүлжээгээр дамжуулан **324 080** хүнд мэдээ, мэдээлэл, видео бичлэгийг хүргээд байна.

Нийт **24642** гарын үсэг цуглуулж илгээгээд байна.

БАЙГУУЛЛАГЫН ӨСӨЛТ ХӨГЖИЛ

УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ, БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

Удирдах Зөвлөл нийт 6 удаа хуралдаж, 24 шийдвэр гаргаснаас ихэнх буюу 90%-ийн биелэлттэй байна. Хяналтын Зөвлөл 2 удаа хуралдаж байгууллагын үйл ажиллагаа дүрмийн дагуу явагдаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж ажилласан байна. Байгууллагаас зохион байгуулсан манлайллын сургалтад Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүд болон байгууллагын гишүүд идэвхтэй оролцжээ.

МЭИ-ийн XIX дүгээр Чуулган 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдаж, Дэлхийн чуулганаар хэлэлцэх шийдвэрүүдэд МЭИ-ийн байр суурь, саналыг баталж, дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн, Удирдах Зөвлөл, Хяналтын Зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнийг сонгон батламжилав.

Мөн тус чуулганд нийт 105 төлөөлөгч оролцож, Бидний харж буй дэлхий ба ирээдүй хойчийнхны эрх сэдвээр Нутгийн шийдэл ТББ-ын тэргүүн Ц.Оюунгэрэл, Хөвсгөл далай ээж ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, Үсгийн урлаг судлаач, каллиграфын мастер Т. Жамъянсүрэн нар уригдан Уур амьсгалын өөрчлөлт, Ус ,Технологи ба соёлын эрх-эх хэл сэдвээр ярилцлаа. Чуулганы төлөөлөгчид Явдаг футболк арга хэмжээнд оролцсоноос гадна орон байртай байх эрхийн асуудлаарх шаардлага уриалгад нэгдэж дуу хоолойгоо өргөлөө.

ЗОРИЛТ

Монголын Эмнести Интернэшнл нь бүлгийн үйл ажиллагааг тогтмолжуулах, идэвхтнүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах, манлайллын чадавхыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмждэг гишүүд дэмжигчид, идэвхтнүүдийн тоог нэмэгдүүлэх

БҮЛЭГ, ГИШҮҮДИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ, ИДЭВХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Цахим, цахим бус сургалт хэлэлцүүлэг, кампанит ажлын үеэр 1099 шинэ гишүүн, дэмжигчтэй болов. Шинэ гишүүдийн сургалт, кампанит ажлын чадавх бэхжүүлэх сургалт, чөлөөт ярилцлага, уулзалт, хэлэлцүүлэг, МЭИ-ээс зохион байгуулдаг тэмцээн уралдаан, кино хэлэлцүүлэг, үзэсгэлэн зэрэг гишүүд болон олон нийтийг хамарсан нийт 170 гаруй удаагийн үйл ажиллагаа зохион байгуулжээ.

МЭИ-ийн 25 жилийн ойг тохиолдуулан илүү эрч хүчтэй ажиллах аяныг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулаа. 25 жилийн ойг тохиолдуулан "Хүний эрх, эрх чөлөө" шог зургийн үзэсгэлэн, тусгай дугаарын ном гаргаж, "Хүний эрхийн үзэл санааны элч" шагналыг бий болголоо.

МЭИ-ийн орон нутгийнхаа бүлгүүдийг дэмжих ажлын хүрээнд 2019 оноос Завхан аймгийн Улиастай хот, Архангай аймгийн Цэцэрлэг хотод бүлгийн гишүүдийг цахим болон цахим бусаар хуралдах, байгууллагын зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулах интернэт кафе нээн ашиглах ажлыг амжилттай эхлээд байна.

2019 онд Баян-Өлгий аймагт албан ёсоор шинэ орон нутгийн бүлэг байгуулагдсан ба МЭИ-ийн сургалтуудыг орон нутгийн гишүүд, дэмжигчдэд амжилттай явуулж, Хүний эрхийн олон улсын өдрийг тохиолдуулан бусад хүний эрхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хүний эрхийн боловсрол, мэдээллийг түгээлээ.

Гишүүдийнхээ олон улсын түвшинд манлайлах чадварыг дэмжих зорилгоор Англи хэлний ярианы Америк багштай клубыг 7 хоног бүрийн Мягмар гарагт явуулж байна. Гишүүд, дэмжигчиддээ хүний эрхийн олон талын боловсрол олгох зорилгоор сар бүр тодорхой асуудлаар бодлогын хэлцлүүлэг, уулзалт тогтмол зохион байгуулаа.

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ЗАЛУУЧУУД

2019 ОНД
БИД

МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛИЙН ЗАЛУУЧУУД:

Бид бол найз нөхөд, хамтран зүтгэгчид.

Бид бол түнэр харанхуйг зүхэн суухын оронд өөрийн гэрэл гэгээг гарган гэрэлтэж буй залуу үеийн төлөөлөл.

Бид бол асуудлыг өөр нүдээр харж, шийдэл хайгч, өсөж, бүтээж яваа залуу хүний эрхийн хамгаалагчид.

МАНЛАЙЛАГЧ ЗАЛУУ ГИШҮҮДЭЭР ӨРГӨЖИВ

2019 онд **19063** залуучуудад хүрч ажилласан бөгөөд үүнээс **4907** залуу гишүүн бидний үйл ажиллагаа, сургалтад хамрагдаж, сайн дурын ажил хийжээ.

Шинэ гишүүний сургалтын модулыг шинэчлэн манлайлагч залуу идэвхтнүүдийг сургагч багшаар бэлтгэв.

Эрүүдэн шүүхийн эсрэг кампанит ажлын хүрээнд **17** залуу сургагч багш бэлтгэгдсэн бөгөөд тэд Эрүүл давлагаа сошиал хөдөлгөөнийг санаачлав.

ЗОРИЛТ

Хүн бүр хүний эрхийг эдэлдэг дэлхий ертөнцийг бүтээхэд залуусын хувь нэмрийг оруулах,

Хүний эрхийн боловсрол түгээх, хүний эрхэд ээлтэй сурггууль бий болгох үйл ажиллагааныхаа хүрээнд **42** үе тэнгийн залуу багш бэлтгэн, **20** сургагч багшийг дадлагажуулан чадавхижуулав.

Залуу хүний эрх хамгаалагч зусланд **24** залуу хамрагдав.

"Жендэрт суурилсан хүчирхийлэл ба хүний эрх" 3 удаагийн цуврал сургалтаар **10** залуу сургагч багш бэлтгэгдсэнээс 4 сургагч багш өөрийн сургалтыг зохион байгуулав.

Орон байртай байх эрх кампанит ажлын хүрээнд эрх зүйн хөтчөөр **2** залуу гишүүн бэлтгэгдэв.

Эрхээ мэдье тэмцээний үндсэн болон туслах **10** шүүгчтэй болов.

СУДЛААЧ ЗАЛУУ ГИШҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, СУРГАЛТ ЯВУУЛАВ

Манлайлал ба багаар ажиллах чадвар сэдвээр,

"Youth-Led action research" сэдэвт сургалтыг зочин илтгэгч урин давхардсан тоогоор **25** залуу гишүүдэд оров.

Судалгааны арга зүй сэдвээр **17** залуу гишүүдэд сургалт орлоо.

"Нэг Эмнести Нэг үнэт зүйл" уулзалт ярилцлагад **22** залуу гишүүд оролцлоо.

Хүний эрхийн англи хэлний сургалт Америк багштайгаар долоо хоногт нэг удаа буюу **2019** оны **36** удаа хичээллэсэн байна.

МЭИ-ийн бодлогын хэлэлцүүлэгт тухайлбал Хар тамхи ба сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодисын хяналт" хэлэлцүүлэгт оролцсон байна.

эрх хамгаалагчийг чадавхижуулах, аюулгүй, эрсдэлгүй орчинд бусадтайгаа хамтран хүний эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчинг бий болгох нөлөөллийн ажил хийгдсэн.

Ярьдаг футболк эвэнтийг 1600 хүн дагаж нийгмийн цахим сүлжээгээр **53400** хүнд хүрэв.

Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, байгууллага, хувь хүний нийт **130** бүтээл ирснээс АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн оюутнуудын 7 бүтээл 5100 удаа шэйрлэгдэн хүмүүст хүрч, тэргүүн байрын шагнал хүртэв.

Өдөрлөгийн арга хэмжээнд давхардсан тоогоор **700** хүн биечлэн оролцсон.

"Ярьдаг Футболк" хүний эрхийн өдөрлөгийг Сантис боловсролын төв, Proteam Фитнесс клуб, Polaris бүжгийн сургалтын төв, УДЭТ, МОНЭС зэрэг байгууллага, Монголын Эмнести Интернэшнлийн Удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал нар ивээн тэтгэж 1,929,500₮-ийн шагналын санг бүрдүүлжээ.

ЗАЛУУЧУУД МАНЛАЙЛАН АЖИЛЛАДАГ БРЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДЫН ҮР НӨЛӨӨ ӨРГӨЖИВ

ЯРЬДАГ ФУТБОЛК-2019

Бид хүний эрхийн боловсролыг дэлгэрүүлэх, хүний эрхийг сурталчлан таниулах үйл ажиллагааны хүрээнд "Ярьдаг Футболк" урлах уралдааныг жил бүр зохион байгуулдаг. Уг парадын хүрээнд хүний эрхийн хамгаалагчыг хүлээн зөвшөөрүүлэх, хүний эрхийн боловсролоор дамжуулан хүний

НАМАЙГ СОНС-2019

Олон улсын Оюутны эрхийг хамгаалах өдрийг үгтан зарласан Оюутны эрх ишлэлийн уралдаанд **167** оюутан оролцов.

Намайг сонс: «Хүний эрхийн төлөө би дуугарч байна» сэдэвт илтгэлийн уралдаан зарлаж **68** оюутан, сурагч оролцов.

SWEET SEPTEMBER-2019

Залуу хүний эрхийн хамгаалагчдыг хүний эрхийн үнэт зүйлсээр нэгтгэх, үнэт зүйлээ үе тэнгийхэнтэйгээ хуваалцах боломж олгох зорилгоор SWEET SEPTEMBER олон нийтийн арга хэмжээг Монголын Эмнести Интернэшнлийн манлайлагч залуусын санаачлагаар зохион байгууллаа. Аяны зохион байгуулалтад 40 гаруй залуу хүний эрхийн хамгаалагчид зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцож, бэлтгэл ажлаас эхлэн аяны өдрийг дуустал нэг залуу гишүүн доод тал нь 27 цагийг хүний эрхийн төлөө хандивлажээ.Тус аяны хүрээнд Уур амьсгалын өөрчлөлт ба Ирээдүй хойчийн эрхийн асуудлаар активизм өрнүүлж, 283 шинэ гишүүн элсүүлжээ.

САЙН ДУРЫНХАН

Сайн дурынхан нь хүний эрхийг хамгаалах, түгээх, хүний эрхийн боловсрол олгох их үйлсэд сургалт сурталчилгаа, кампанит ажил зохион байгуулах, мэдээллийг орчуулах, түгээх, тараах материал бэлдэх, гишүүд дэмжигчидтэй харилцах зэргээр мэдлэг, боломж, цагаа үнэ хөлсгүйгээр зориулдаг гишүүд, дэмжигч, хүний эрхийн идэвхтнүүд юм.

2019 онд Монголын Эмнести Интернэшнл байгууллагад нийт 20 гаруй сайн дурын ажилтан, идэвхтнүүд урт болон богино хугацаагаар гэрээ байгуулан нийт 498 цагийг хүний эрхийн төлөөх үйлсэд хандивлан ажиллаа. Үүнээс гадна гишүүн, дэмжигчид байгууллагаас зохион байгуулсан үйл ажиллагаануудад сайн дурын ажил хийх байдлаар идэвхитэй оролцлоо.

МУИС-ийн ОУХС-ийн 1, МУИС-ийн Нийгмийн Ухааны Сургуулийн 3 нийт дөрвөн оюутан мэргэжлийн дадлага хийв.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САЛБАР: МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

ОРЛОГО 2019		2019 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31	2019 оны 1 сарын 01-нээс 12 сарын 31
		Төсөв (ам. доллар)	Гүйцэтгэл (ам. доллар)
Гишүүдийн татвар, хандивын тогтмол төлөлт		4,500.00	1,320.43
Тогтмол бус хандив		3,400.00	1,484.47
Тэтгэлэг олгогчийн санхүүжилт		4,100.00	10,806.25
Бусад сан арвижуулалтын орлого		37,602.00	9,556.04
Гаднаас олсон нийт орлогын дүн		**49,602.00**	**23,167.19**
ОУТөвийн санхүүжилт		**164,529.00**	**166,944.34**
НИЙТ САНХҮҮЖИЛТ		**214,131.00**	**190,111.53**
ЗАРЛАГА 2019			
Хүний эрхийн стратегийн зорилт	Зорилго 1 - 4	116,652.95	95,134.25
Өсөлтийн стратегийн зорилт Зорилго 5	Зорилго 5 - Сан арвижуулах	12,460.00	7,857.52
	Зорилго 5- Бусад асуудал	23,111.23	23,686.75
Стратегийн зорилгоос гаднах хүний эрхийн үйл ажиллагаа		7,702.57	8,661.11
Удирдлага, дотоод ардчилал болон бусад дэмжих ажиллагааны зардал		54,204.25	50,355.11
НИЙТ ЗАРДАЛ		**214,130.99**	**185,694.74**
	Эхний үлдэгдэл		
	Бэлэн мөнгө [касс ба банк]	82,900.85	
	Нөөц сан	41,334.05	
	Урьдчилж төлсөн төлбөр	153.50	
	Авлага	2,728.76	
	Өглөг	13,717.07	
	Эцсийн үлдэгдэл		
	Бэлэн мөнгө [касс ба банк]		78,629.43
	Нөөц сан		42,548.62
	Урьдчилж төлсөн төлбөр		75.74
	Авлага		4,561.64
	Өглөг		7,998.55

Хянасан гүйцэтгэх захирал: Б. Алтантуяа

Тайланг боловсруулсан ня-бо: Т. Ариунаа

Аудит хийсэн Аудитор: О. Чулуунбаатар /Эс-Эм Аудит ХХК/

БҮХ ЗҮЙЛ ТАНААС ЭХЭЛДЭГ

ТАНЫ ТӨЛСӨН ТАТВАР, ХАНДИВ, ХУДАЛДАН АВАЛТ ДАРААХ ЗҮЙЛСЭД ЗАРЦУУЛАГДДАГ.

- **СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ** нэгэн илрүүлэх, үнэнийг өгүүлэх
- **ОЛОН УЛСЫН КАМПАНИТ АЖЛУУД** хүний эрхийн асуудалд анхаарал хандуулахад уриалах
- **ЗАСГИЙН ГАЗАРТ ШАХАЛТ ҮЗҮҮЛЭХ** хүний эрхийн асуудлыг анхааралдаа авахыг шаардах
- **ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГЧДӨД** хүчирхийлэл үйлдэхээ зогсоохыг шаардах
- **ХЯМРАЛД ХАРИУ ӨГӨХ** хүний эрхийг хамгаалах яаралтай үйл ажиллагаа явуулах
- **СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА** олон нийттэй харьцах, мэдээ, мэдээлэл хүргэх
- **ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДАД** хүний эрхийн боловсрол олгох чадавхжуулах

ҮҮНИЙ ҮР ДҮНД БИД:

- ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ СУРГУУЛИУДЫГ ДЭМЖДЭГ
- ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛДАГ
- ЦААЗААР АВАХ ЯЛЫН ХОР ҮРШГИЙГ ТАНИУЛДАГ
- ЭРҮҮДЭН ШҮҮХ, ХҮНЛЭГ БУСААР ХАРЬЦАХТАЙ ТЭМЦДЭГ
- ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ШААРДДАГ
- ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХОХИРОГЧДЫГ ХАМГААЛДАГ
- ГИШҮҮН ӨРГӨЖҮҮЛЖ, ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ХҮРЭЭГ ТЭЛДЭГ
- ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛДЭГ
- ГИШҮҮД, ДЭМЖИГЧДИЙН ЧАДАВХИ БЭХЖҮҮЛДЭГ
- ЦАХИМ ОРЧИНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛДЭГ
- ЭРСДЭЛД БУЙ ХҮВЬ ХҮМҮҮСИЙГ ХАМГААЛДАГ

ӨГӨӨМӨР ДЭМЖИГЧИД

Эмнести Интернэшнл судалгаа, кампанит ажлуудаараа бүсдад танигдсан хэдий ч өгөөмөр дэмжигчидгүйгээр энэ бүхнийг хийх боломжгүй юм.

Хандивласан хөрөнгө нь манай байгууллагын дараах кампанит ажилд хувь нэмэр оруулаа.

- Хүний эрхийн боловсрол
- «Эрүүдэн шүүхийн эсрэг» кампанит ажил
- «Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх» кампанит ажил
- Цаазаар авах ялын эсрэг кампанит ажил

ХҮНИЙ ЭРХЭД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХ ҮНЭХЭЭР АМАРХАН

Хүний эрхийн төлөө тэмцэнэ гэдэг нь та заавал гудамжинд уриа лоозон барьж жагсана гэсэн үг биш. Эмнести Интернэшнлийн үйл ажиллагааг дэмжиж гишүүн болох, мөнгө хандивлах зэрэг нь дэлхий дахинд хүний эрх, шударга ёс авчрахын төлөө таны оруулж буй хувь нэмэр юм.

Та **WWW.AMNESTY.MN** цахим хуудсаар зочлон бидний хийж буй хүний эрхийн төлөөх ажлуудтай танилцан доорх дансаар мөнгө хандивлаж болно.

Голомт банк: 112098352

Хаан банк:
₮ данс

Худалдаа хөгжлийн банк:
$ данс

NEW ERA
ЭМНЕСТИ
хамтдаа шоглох
дээрэлхэхийн
эсрэг
тэмцэцгээе!!!
ALUMNI WALL